

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ТҮНТ-ИЙН
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-05-НЫ
ӨДРҮҮДЭД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2023 оны 01 дүгээр сарын 05

Хэрлэн сум

Өргөдөл гомдол санал хүсэлтийн мэдээлэл: 70563111 утсанд 6 санал хүсэлт, өргөдөл гомдол ирсэн. Шийдвэрлэгдсэн 2, шийдвэрлэлтийн шатандаа 4, А-57-р байрны оршин суугчдаас СӨХ-ийн үйл ажиллагаатай 3, группээс хасагдсанд гомдолтой байна, Тээвэрчидийн 20-20 тоот оршин суугчаас халаалттай холбоотой гомдол ирснийг Хэнтий Ус ХХК-аас хариуг өгсөн.

Засгийн газрын 1111 төвд 3 өргөдөл ирсэн. Бор-Өндөр сумын хот тохижилтын газар иргэдээс их хэмжээний мөнгө авч байна. Иргэний үнэмлэхэд сунгалт хийлгэхэд торгуулийн мөнгийг суманд хийлгэхгүй заавал аймаг орж улсын бүртгэгчтэй уулзаж мөнгөө хийлгэнэ гэж чирэгдэл үүсгэж байна, Батширээт суманд гал гарч дэлгүүр шатахад сумын зүгээс ямар нэгэн тусламж дэмжлэг үзүүлэхгүй байна гэсэн утгатай өргөдөл ирснийг АЗДТГ-ын даргад танилцуулагдан шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нийт 532 иргэн үйлчлүүлж Утсаар 26, цахимар 23, өөртөө үйлчлэх танхимаар 216, Үүнээс биечлэн 267 иргэн үйлчлүүлснээс. Улсын бүртгэлээр 98, Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр 80, Газрын үйлчилгээгээр 15, Нийгмийн даатгал 21, Хууль зүйн зөвлөгөөгөөр 10 иргэнд зөвлөгөө өгсөн, e-mongolia сурталчилах цэгээр 10, E-khutuch.mn булангаар 5, Төрийн банк 28 иргэнд үйлчлүүлсэн.

Үнэлгээний төхөөрөмжинд 267 үнэлгээ өгөгдсөнөөс: Маш сайн 265, сайн 2, байна.